



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠭᠠᠷ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2021 I-II

ГАРЧИГ

1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ	1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл.....	1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	2
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.....	4
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар.....	4
2.1.3. Газрын тосны салбар	4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн	7
2.4. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад.....	8
3. ГАДААД ХУДАЛДАА.....	9
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	9
3.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	10
3.1.2. Газрын тосны салбар	11
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар.....	11
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт.....	11
3.2.1. Газрын тосны салбар	11



1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Улсын Их Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
			Төлөвлөгөө	I-II сар		
1	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	37,200.0	4,576.3	32,623.7	12.3%
2	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	1,438.0	225.9	1,212.1	15.7%
3	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	8,900.0	1,210.2	7,689.8	13.6%
4	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан) ¹	тн	11.3	2.0	9.3	17.6%
5	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.бар	5,794.0	954.8	4,839.2	16.5%
6	Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ²	мян.тн	119.2	21.8	97.4	18.3%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ³	мян.тн	714.0	124.9	589.1	17.5%

Эх сурвалж Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Монголбанк

1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 1,720.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 256.2 тэрбум төгрөг буюу 17.5 хувиар өссөн байна.

Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 541.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 194.6 тэрбум төгрөг буюу 56.0 хувиар өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхайн салбараас 505.3 тэрбум төгрөг буюу 29.4 хувь,
- Газрын тосны салбараас 30.9 тэрбум төгрөг буюу 1.8 хувь,
- Тусгай зөвшөөрлийн төлбөр 3.6 тэрбум төгрөг буюу 0.2 хувь,
- Бусад орлого 2.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувь.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 31.5 хувийг бүрдүүлж байна.

¹ Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.

² Цайр нь МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно

³ Хайлуур жонш нь МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл / I-II сар /		Гүйцэтгэл	
		2020 (Тодотгол)	2021	2020	2021	Өсөлт, бууралт	Хувь
Нийт дүн		2,857.3	3,631.9	347.3	541.9	194.6	56.0%
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР							
Нийт дүн		2,698.1	3,396.5	320.6	505.3	184.8	57.6%
1	Алт	212.6	231.0	14.8	13.7	-1.1	-7.4%
2	Зэс	1,127.7	1,467.0	132.1	320.5	188.4	142.6%
3	Нүүрс	1,056.3	1,337.0	144.9	119.2	-25.7	-17.7%
4	Бусад	301.5	361.5	28.8	52.0	23.2	80.5%
ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР							
5	Газрын тос	110.0	183.2	21.0	30.9	9.8	46.7%
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО							
Нийт дүн		49.2	52.2	5.7	5.7	0.05	0.9%
6	Тусгай зөвшөөрлийн төлбөр	30.0	31.2	4.5	3.6	-0.9	-19.2%
7	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	6.6	2.5	0.3	0.2	-0.1	-26.8%
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/	9.0	16.0		0.9	0.9	100.0%
9	Бусад орлого	3.6	2.5	0.9	1.0	0.1	12.7%

Эх сурвалж: Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 – дахин их

1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр улсын төсөвт 505.3 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 320.5 тэрбум төгрөг,
- Нүүрс 119.2 тэрбум төгрөг,
- Төмөр 19.1 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 17.3 тэрбум төгрөг,
- Алт 13.7 тэрбум төгрөг,
- Цайр 12.9 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 2.6 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 184.8 тэрбум төгрөг буюу 57.6 хувиар өссөн байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Зэс 188.4 (2.4 дахин) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 15.5 (9.6 дахин) тэрбум төгрөг,
- Төмөр 9.5 (99.0%) тэрбум төгрөг,
- Цайр 7.8 (2.5 дахин) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 25.7 (17.7%) тэрбум төгрөг,
- Бусад 9.7 (78.5%) тэрбум төгрөг,
- Алт 1.1 (7.4%) тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2020		2021		Өөрчлөлт			
	I сар	I-II сар	I сар	I-II сар	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	191.6	320.6	364.9	505.3	173.3	90.4%	184.8	57.6%
Алт	7.3	14.8	6.6	13.7	-0.7	-9.8%	-1.1	-7.4%
Нүүрс	80.0	144.9	70.2	119.2	-9.8	-12.2%	-25.7	-17.7%
Цайр	2.2	5.1	8.3	12.9	6.2	3.8 ¹	7.8	2.5 ¹
Зэс	88.4	132.1	262.6	320.5	174.2	3.0 ¹	188.4	2.4 ¹
Төмөр	8.3	9.6	6.4	19.1	-1.9	-23.0%	9.5	99.0%
Хайлуур жонш	1.1	1.8	9.5	17.3	8.4	8.5 ¹	15.5	9.6 ¹
Бусад	4.4	12.3	1.3	2.6	-3.0	-69.6%	-9.7	-78.5%

Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 – дахин их



2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.1. Уул уурхай, олборлох салбар

2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 8,817.2 мян.тн нүүрс, 212.6 мян.тн зэсийн баяжмал, 1,665.9 кг алт, 876.4 тн молибдены баяжмал, 26.1 мян.тн хайлуур жоншны хүдэр, 9.0 мян.тн хайлуур жоншны баяжмал, 505.6 мян.тн төмрийн хүдэр, 338.4 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 15.5 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 3,191.5 мян.тн буюу 56.7 хувь, зэсийн баяжмал 9.8 мян.тн буюу 4.8 хувь, алт 196.1 кг буюу 13.3 хувь, хайлуур жоншны хүдэр 8.5 мян.тн буюу 48.3 хувь, хайлуур жоншны баяжмал 6.6 мян.тн буюу 3.8 дахин, цайрын баяжмал 1.7 мян.тн буюу 12.6 хувиар тус тус өссөн байна.

Харин молибдены баяжмал 78.2 тн буюу 8.2 хувь, төмрийн хүдэр 6.9 мян.тн буюу 1.3 хувь, төмрийн хүдрийн баяжмал 41.0 мян.тн буюу 10.8 хувиар буурсан байна.

2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 873.4 мян.тн баяжуулсан нүүрс, 250.1 мян.тн нүүрсэн шахмал түлш, 1,579.2 тн катодын зэс, 29.1 тн металл бэлдэц, 830.0 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрс 515.6 мян.тн буюу 2.4 дахин, нүүрсэн шахмал түлш 109.0 мян.тн буюу 77.3 хув, ган төмөр хийц 107.7 тн буюу 14.9 хувиар тус тус өссөн байна.

Харин катодын зэс 141.9 тн буюу 8.2 хувь, металл бэлдэц 4.6 мян.тн буюу 99.4 хувь, металл цувимал 7.0 мян.тн буюу 100 хувиар тус тус буурсан байна.

2.1.3. Газрын тосны салбар

2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 997.4 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 576.1 мян.бар буюу 2.4 дахин их өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2020		2021*		Өөрчлөлт			
			I	I-II	I	I-II	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1. Уул уурхай, олборлолт										
1.1	Нүүрс	мян.тн	2,754.6	5,625.8	4,227.8	8,817.2	1,473.2	53.5%	3,191.5	56.7%
1.2	Газрын тос	мян.бар	45.5	421.4	469.0	997.4	423.5	10.3 ¹	576.1	2.4 ¹
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	94.6	202.8	104.1	212.6	9.5	10.1%	9.8	4.8%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	461.7	954.6	404.4	876.4	-57.3	-12.4%	-78.2	-8.2%
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	785.1	1,469.8	964.9	1,665.9	179.8	22.9%	196.1	13.3%
1.6	Төмрийн хүдэр, баяжмал:	мян.тн								
	- Төмрийн хүдэр	мян.тн	303.9	512.5	307.2	505.6	3.3	1.1%	-6.9	-1.3%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	226.2	379.4	170.6	338.4	-55.7	-24.6%	-41.0	-10.8%
1.7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал:	мян.тн								
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	8.7	17.6	14.9	26.1	6.3	72.1%	8.5	48.3%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	1.1	2.3	3.0	9.0	1.9	2.7 ¹	6.6	3.8 ¹
1.8	Цайрын баяжмал	мян.тн	6.0	13.7	6.7	15.5	0.7	12.1%	1.7	12.6%
2. Боловсруулах үйлдвэр										
2.1. Хүнд үйлдвэр										
2.1.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	157.3	357.8	322.9	873.4	165.6	2.1 ¹	515.6	2.4 ¹
2.1.2	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	71.0	141.1	124.6	250.1	53.6	75.5%	109.0	77.3%
2.1.3	Катодын зэс, 99%	тн	817.3	1,721.1	778.9	1,579.2	-38.3	-4.7%	-141.9	-8.2%
2.1.4	Металл бэлдэц	тн	2,158.4	4,616.8	10.2	29.1	-2,148.2	-99.5%	-4,587.7	-99.4%
2.1.5	Металл цувимал	тн	3,390.8	7,069.8			-3,390.8	-100.0%	-7,069.8	-100.0%
2.1.6	Ган төмөр хийц	тн		722.3	412.0	830.0	412.0	100.0%	107.7	14.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их



2.2. АЖҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2020		2021*		Өөрчлөлт			
	II	I-II	II	I-II	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,046.2	2,209.3	1,473.6	3,054.5	427.4	40.9%	845.2	38.3%
Уул уурхай, олборлолт	656.5	1,417.2	1,027.5	2,113.4	371.0	56.5%	696.2	49.1%
Нүүрс олборлолт	262.4	501.7	404.7	905.3	142.3	54.2%	403.6	80.4%
Газрын тос олборлолт	7.4	68.0	70.2	144.1	62.8	9.5 ¹	76.0	2.1 ¹
Металлын хүдэр олборлолт	369.6	807.0	535.2	1,033.0	165.6	44.8%	226.0	28.0%
Бусад ашигт малтмал олборлолт	7.2	15.7	13.5	25.0	6.3	87.8%	9.3	59.3%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	10.0	24.7	4.1	5.9	-5.9	-59.3%	-18.8	-75.9%
Боловсруулах үйлдвэр	251.6	512.2	294.6	637.6	43.0	17.1%	125.4	24.5%
Үүнээс, хүнд үйлдвэр	67.0	134.0	92.3	216.1	25.3	37.8%	82.1	61.3%
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	39.0	79.6	58.4	157.4	19.3	49.5%	77.8	97.8%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6.6	12.7	11.8	20.7	5.2	79.7%	8.0	62.6%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	2.1	4.4	10.4	14.6	8.3	4.9 ¹	10.2	3.3 ¹
Металл боловсруулах үйлдвэрлэл	18.9	36.8	11.3	22.8	-7.6	-40.3%	-14.0	-38.0%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.3	0.5	0.3	0.6	0.0	16.5%	0.1	15.7%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 3.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 845.2 (38.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 696.2 (49.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 403.6 (80.4%) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт 226.0 (28.0%) тэрбум төгрөг, газрын тос олборлолт 76.0 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин уул уурхайн туслах үйл ажиллагаа 18.8 (75.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 69.2 хувийг эзэлж байна.



2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2020		2021*			Өөрчлөлт	
	II	I-II	II	I-II	Гад- дад	(4-2)=?, (4/2)=%	
1	2	3	4	5	6	7	8
Нийт дүн	911.4	2,177.8	1,976.7	4,068.2	2,872.2	1,890.5	86.8%
Уул уурхай, олборлолт	473.0	1,186.2	1,455.9	2,992.1	2,645.1	1,805.9	2.5 ¹
Нүүрс олборлолт	81.2	323.1	464.6	1,033.6	949.5	710.5	3.2 ¹
Газрын тосны олборлолт		46.4	65.2	137.8	137.8	91.3	3.0 ¹
Металлын хүдэр олборлолт	359.7	751.3	900.7	1,767.5	1,523.1	1,016.2	2.3 ¹
Бусад ашигт малтмал олборлолт	13.3	27.5	21.3	48.2	34.8	20.7	75.3%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	18.9	37.9	4.1	5.1		-32.8	-86.6%
Боловсруулах үйлдвэр	299.4	710.5	368.8	771.9	227.1	61.5	8.7%
Үүнээс, хүнд үйлдвэр	69.4	256.0	125.7	266.1	189.3	10.1	3.9%
Кокс, газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18.8	149.0	56.6	144.6	110.7	-4.5	-3.0%
Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6.9	13.6	12.9	22.5		8.9	65.9%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	4.8	9.3	7.9	14.4		5.1	55.2%
Металл боловсруулах үйлдвэрлэл	38.4	83.6	47.9	84.0	78.6	0.4	0.5%
Машин, ТТ-өөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.4	0.5	0.4	0.5		-0.0	-1.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 4.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (86.8%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 3.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 (2.5 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 710.5 (3.2 дахин) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 1.0 (2.3 дахин) их наяд төгрөг, газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 91.3 (3.0 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин уул уурхайн туслах үйл ажиллагааны салбарын борлуулалт 32.8 (86.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 2.9 их наяд төгрөг буюу 70.6 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 2.6 их наяд төгрөг буюу буюу 92.1 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.



2.4. АЖҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

хүнээр

Салбар	2018	2019	2020	2021*	Өөрчлөлт			
	I-II сар				(5-3)=?, (5/3)=%		(5-4)=?, (5/4)=%	
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	71,665	74,614	77,958	82,149	7,535	10.1%	4,191	5.4%
Уул уурхай, олборлолт	22,174	22,437	23,109	24,933	2,496	11.1%	1,824	7.9%
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	7,972	7,989	7,266	7,999	10	0.1%	733	10.1%
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	1,501	1,569	1,575	1,398	-171	-10.9%	-177	-11.2%
Металлын хүдэр олборлолт	11,194	11,356	12,599	12,332	976	8.6%	-267	-2.1%
Бусад ашигт малтмал олборлолт	1,507	1,411	1,523	3,008	1,597	113.2%	1,485	97.5%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа		112	146	196	84	75.0%	50	34.2%
Боловсруулах үйлдвэр	28,321	29,902	32,108	33,259	3,357	11.2%	1,151	3.6%
Үүнээс, хүнд үйлдвэр	4,022	4,091	4,520	4,742	651	15.9%	222	4.9%
Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	392	482	929	940	458	95.0%	11	1.2%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	2,048	1,794	1,944	2,078	284	15.8%	134	6.9%
Металл боловсруулах үйлдвэрлэл	1,511	1,699	1,554	1,636	-63	-3.7%	82	5.3%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	71	116	93	88	-28	-24.1%	-5	-5.4%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 – дахин их

3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний 2 сарын байдлаар 2.3 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 736.1 сая ам.доллараар буюу 48.4 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 412.3 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

сая ам.доллар										
Үзүүлэлт	Жилээр			Өөрчлөлт		I-II сар			Өөрчлөлт	
	2018	2019	2020	2020/2019		2019	2020	2021	2021/2020	
				Дүн	%				Дүн	%
Эргэлт	12,887	13,747	12,870	-877	-6%	1,931	1,521	2,257	736	48%
Экспорт	7,012	7,620	7,576	-44	-1%	1,094	771	1,335	564	73%
Импорт	5,875	6,127	5,294	-833	-14%	838	750	922	172	23%
Тэнцэл	1,137	1,493	2,282	789	53%	256	21	412	392	19.9 ¹

сая ам.доллар

Тайлбар: 1 - дахин их

3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.2 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 486.4 сая ам.доллараар буюу 66.4 хувиар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, жонц молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 91.3 хувийг эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2020	2021	Өөрчлөлт	
		I-II сар		Өсөлт/бууралт	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	82.3	98.7	16.4	20.0%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,139.6	1,933.6	794.0	69.7%
Түүхий нефть болон газрын тос	бар/ам.дол	58.8	52.5	-6.3	-10.8%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	69.3	121.6	52.3	75.5%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,343.2	1,487.7	144.5	10.8%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	246.0	220.5	-25.4	-10.3%
Молибдены хүдэр, баяжмал	тн/ам.дол	7,000.5	6,980.6	-19.9	-0.3%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3.1.1. Уул уурхай, олборлох салбар

Чулуун нүүрсний экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 447.1 сая ам.долларын 4.5 сая тн чулуун нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 218.2 сая ам.доллараар буюу 95.3 хувиар, биет хэмжээгээр 1.7 сая тн-оор буюу 62.8 хувиар тус тус өссөн байна. 1 тн чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 98.7 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 16.4 ам.доллараар буюу 20.0 хувиар өссөн байна. Чулуун нүүрсний 92.8 хувийг БНХАУ руу, 6.5 хувийг Сингапур Улс руу тус тус экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 436.8 сая ам.долларын 225.9 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 217.7 сая ам.доллараар буюу 99.4 хувиар, биет хэмжээгээр 33.6 мян.тн-оор буюу 17.5 хувиар тус тус өссөн байна. 1 тн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1,933.6 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 794.0 ам.доллараар буюу 69.7 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 147.1 сая ам.долларын 1,210.2 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 48.2 сая ам.доллараар буюу 48.8 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 217.2 мян.тн-оор буюу 15.2 хувиар буурсан байна. 1 тн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 121.6 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 52.3 ам.доллар буюу 75.5 хувиар өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 27.5 сая ам.долларын 124.8 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 42.6 мян.тн-оор буюу 51.9 хувиар, үнийн дүнгээр 7.3 сая ам.доллараар буюу 36.2 хувиар тус тус өссөн байна. 1 тн хайлуур жоншны экспортын дундаж үнэ 220.5 ам.доллар болж, 25.4 ам.доллар буюу 10.3 хувиар буурсан байна. Хайлуур жоншны 79.6 хувийг БНХАУ руу, 20.4 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 32.5 сая ам.долларын 21.8 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 4,606.2 тн-оор буюу 17.4 хувиар, үнийн дүнгээр 3,029.3 мян.ам.доллараар буюу 8.5 хувиар тус тус буурсан байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,487.7 ам.доллар болж, 144.5 ам.доллар буюу 10.8 хувиар өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 6.9 сая ам.долларын 993.5 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 342.5 мян.ам.доллараар буюу 4.7 хувиар, биет хэмжээгээр 46.1 тн-оор буюу 4.4 хувиар тус тус буурсан байна. 1 тн молибдены баяжмалын экспортын дундаж үнэ 6,980.6 ам.доллар болж, 19.9 ам.доллараар буюу 0.3 хувиар буурсан байна. Молибдены баяжмалын 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

3.1.2. Газрын тосны салбар

Газрын тосны экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 50.1 сая ам.долларын 954.8 мян.бар газрын тос экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 667.1 мян.бар-иар буюу 231.8 хувиар, үнийн дүнгээр 33.2 сая ам.доллар буюу 196.1 хувиар тус тус өссөн байна. 1 бар газрын тосны экспортын дундаж үнэ 52.5 ам.доллар болж, 6.3 ам.доллараар буюу 10.8 хувиар буурсан байна.

3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар

Коксын экспорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 7.2 сая ам.долларын 28.4 мян.тн кокс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 7.2 сая ам.доллараар буюу 103.4 дахин, биет хэмжээгээр 28.0 мян.тн-оор буюу 68.9 дахин ихээр тус тус өссөн байна.

Катодын зэс: 2021 оны эхний 2 сарын байдлаар 14.0 сая ам.долларын 1,761.4 тн катодын зэс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 360.2 тн-оор буюу 17.0 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 1.9 сая ам.доллараар буюу 16.0 хувиар өссөн байна.

3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2021 оны эхний 2 сарын байдлаар 922.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 172.3 сая ам.доллараар буюу 23.0 хувиар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт 177.2 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 36.2 сая ам.доллараар буюу 17.0 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний импортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2020	2021	Өөрчлөлт	
		I-II сар		Өсөлт/бууралт	Хувь
Автобензин	тн/ам.дол	630.7	466.7	-164.0	-26.0%
Дизель түлш	тн/ам.дол	637.8	479.9	-157.9	-24.8%

3.2.1. Газрын тосны салбар

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 83.0 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2021 оны эхний 2 сарын байдлаар 147.1 сая ам.долларын 297.3 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 14.7 мян.тн-оор буюу 5.2 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 35.4 сая ам.доллар буюу 19.4 хувиар буурсан байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 87.2 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 24.8 хувийг автобензин, 62.5 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.



Автобензины импорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 36.4 сая ам.долларын 78.1 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 3.3 мян.тн-оор буюу 4.0 хувиар, үнийн дүнгээр 14.9 сая ам.доллараар буюу 29.0 хувиар тус тус буурсан байна. 1 тн автобензины импортын дундаж үнэ 466.7 ам.доллар болж, 164.0 ам.доллараар буюу 26.0 хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт: 2021 оны эхний 2 сарын байдлаар 91.9 сая ам.долларын 191.5 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 12.1 сая ам.доллараар буюу 11.7 хувиар буурсан ч, биет хэмжээгээр 28.4 мян.тн буюу 17.4 хувиар өссөн байна. 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ 479.9 ам.долларт болж, 157.9 ам.доллараар буюу 24.8 хувиар буурсан байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ